



ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

“ГЭРЧ, ХОХИРОГЧИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ” ХУУЛИЙН
ТӨСЛИЙН ЗАРДЛЫН ТООЦОО

2018

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

“ГЭРЧ, ХОХИРОГЧИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ” ХУУЛИЙН ТӨСЛИЙН ЗАРДЛЫН ТООЦОО ¹

УДИРТГАЛ

Хууль тогтоомжийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1-д “Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг санаачлах, боловсруулах ажиллагааны үндэслэл, чанарыг сайжруулах, түүнд олон нийтийн оролцоог хангах, хууль тогтоомжийн төсөлд тавих шаардлагыг тодорхойлох, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэх замаар хууль дээдлэх ёсыг бэхжүүлнэ” гэж заасан. Мөн “Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн “Тав” дахь хэсгийн 5.1.22-т “Хууль зүйн судалгааны чанарыг шинэ түвшинд гаргаж, хууль тогтоомжийн боловсруулалт, хэрэгжилтийг судалгаанд суурилан хөгжүүлэх боломжийг бүрдүүлнэ”, 5.3.6-д “Гэрч, хохирогчийн аюулгүй байдал, нууцлалыг хамгаалах чиглэлээр эрх зүйн орчинг боловсронгуй болгож гэрч, хохирогчийн хамгаалалтын цогц механизмыг бүрдүүлнэ” гэж тус тус заасан.

Иймд Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ыг баримтлан Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /цаашид “төсөл” гэх/ дэх зардал, ачааллыг тооцох, зардлыг багасгах санал боловсруулахад энэхүү судалгааны зорилго чиглэнэ.

Түүнчлэн энэхүү судалгаагаар хууль тогтоомжийг хэрэгжүүлэх явцад хэдий хэмжээний зардал, ачаалал үүсгэхийг урьдчилан гаргах юм. Уг төсөлд иргэн, хуулийн этгээдэд зардал, ачаалал үүсгэх, үүрэг болгосон заалт тусгаагүй, харин төрийн байгууллагад зардал, ачаалал үүсгэх зохицуулалт байна. Иймд тухайн үүргийг хэрэгжүүлэх төрийн байгууллага буюу улсын төсөвт үүсэх зардал, ачааллыг аргачлалын дагуу дараах алхмаар тооцож үзлээ. Үүнд:

1. Төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг;
2. Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийн зардлыг тооцох;
3. Гарах зардлыг урьдчилан тооцоолох;
4. Нийт дүнг тооцон тэдгээрийг бууруулах боломжтой эсэхийг судлан боломжит хувилбарыг дэвшүүлэхийг зорьсон болно.

НЭГ. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ

1.1. Төрийн байгууллагын гүйцэтгэх үүргийг тодорхойлох

Төслийн 1 дүгээр зүйлийн 1-10 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 1-3 дахь хэсгүүдэд төрийн байгууллагад үүсэх зардалтай шууд ба шууд бус хамаарал бүхий зохицуулалт орсон боловч төрд зайлшгүй зардал ачаалал үүсгэх үүргийг бий болгосон зохицуулалтыг тодорхойлон, тэдгээрийн хоорондын уялдаа холбоог анхааран үзэж голлон үүрэг гүйцэтгэх байгууллага, түүнд хамааралтай заалтыг авч үзлээ.

¹ Тус судалгааг Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, хууль зүйн доктор, дэд профессор П.Амаржаргал удирдан, эрдэм шинжилгээний ажилтан Э.Уянга, С.Цэрэндолгор нар хамтран гүйцэтгэв.

Хүснэгт 1. Төрийн байгууллагад үүрэг хүлээлгэсэн заалт

Хуулийн төслийн зүйл, заалт	Зохицуулалт	Хэрэгжүүлэх байгууллага
1 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг/ 18 дугаар зүйлийн 18.1.4.	Нийгмийн бусад туслалцаа	Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, 23.2 дахь хэсэгт заасан байгууллагууд буюу Цагдаагийн алба, Авлигатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газар
3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг/ 7 дугаар зүйлийн 7.2.	Шаардлагатай гэж үзвэл энэ хуулийн 7.1-д заасан хамгаалалтын арга хэмжээг хамтатган хэрэглэж болно. Хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэхэд болон энэ хуулийн 18.1.4-т заасан нийгмийн бусад туслалцаа үзүүлэхэд шаардагдах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.	Цагдаагийн алба, Авлигатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газар

Дээрх хүснэгтэд дурдсан “хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх”-д болон “нийгмийн бусад туслалцаа” үзүүлэхэд шаардлагатай зардалд хамаарагдах хүчин зүйлсийг тодорхойлохын зэрэгцээ улсын төсөвт үүсэх зардлыг урьдчилан тооцох болно.

Түүнчлэн хуулийн төсөлд дурдсан бүх байгууллагын зардлыг биш гүйцэтгэх үүрэгт гол ачаалал үүрэх байгууллагыг сонгон² авч зардлыг тооцох юм. Гол ачаалал үүрэх байгууллага нь судалгааны хүрээнд Хууль зүйн сайдын 2014 оны А/114 дүгээр тушаалаар батлагдсан журмын³ 6 дугаар зүйлийн 6.1-д “Тусгай хамгаалах болон хамгаалах байранд байгаа гэрч, хохирогчид Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль /цаашид “ГХХтХ” гэх/-ийн 18-д заасан үйлчилгээг Цагдаагийн албаны гэрч, хохирогчийг хамгаалах нэгжийн дэргэдэх, хамгаалалтын тусгай нэгжийн дэргэдэх мэргэжлийн баг үзүүлнэ” гэж заасны дагуу Цагдаагийн ерөнхий газар /цаашид “ЦЕГ” гэх/-ын дэргэдэх Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэс гол үүргийг гүйцэтгэхээр байна.

Тус байгууллагын хүний нөөцийн зардал, материаллаг зардлыг авч үзэх боломжтой бөгөөд хамгаалах байрны зардлыг авч үзэх боломжгүй байна. Учир нь Хууль зүйн сайдын 2014 оны А/114 дүгээр тушаалд “...хамгаалах байрны байршил, гэрч, хохирогчийн талаарх мэдээллийн нууцлалыг задруулахгүй байх”, “журмыг зөрчсөн албан тушаалтанд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ” гэж заасан.

Иймд хамгаалалтад авсан иргэдээс Нийслэлийн Цагдаагийн газар /цаашид “НЦГ” гэх/-ын дэргэдэх “Түр хамгаалах байр” болон ХЭҮТ, ХТЭТ-ийн хамгаалах байранд байрлуулж, хэлтсийн зүгээс шаардлагатай үйлчилгээг үзүүлдэг⁴ байх тул эдгээр байруудын “нийгмийн бусад туслалцаа” үзүүлж буй үйл ажиллагааг эрх зүйн акт болон холбогдох албан хаагчдаас авсан мэдээлэлд тулгуурласан.

² Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалын гарын авлага. Хууль тогтоомжийн тухай хууль /аргачлал, гарын авлага/, Хууль зүй, дотоод хэргийн яам, ГИЗ, УБ., 2016 он, 279 дэх тал.

³ Хууль зүйн сайдын 2014 оны А/114 дүгээр тушаал /Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/153 дугаар тушаалаар өөрчлөлт орсон/, <http://www.legalinfo.mn/annex/details/6426?lawid=10466> (сүүлд үзсэн 2018.10.17)

⁴ Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн ахлах мэргэжилтэн Ш.Шинэбаяртай хийсэн ярилцлага. (2018.10.17)

1.2. Стандарт үйл ажиллагааг тодорхойлох

Хуулийн төсөлд туссан “хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх”-д болон “нийгмийн бусад туслалцаа” үзүүлэхэд гол үүрэг гүйцэтгэх байгууллага болох ЦЕГ-ын дэргэдэх Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн гүйцэтгэх үүрэг, стандарт үйл ажиллагааг дараах байдлаар авч үзлээ.

Хүснэгт 2. Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг, стандарт үйл ажиллагаа

Үүргийг хэрэгжүүлэх байгууллага	Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээ		Стандарт үйл ажиллагаа	
ЦЕГ-ын дэргэдэх Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэс	Хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх /ГХХТХ-ийн хоёрдугаар бүлэг/	Аюулгүй байдлын хамгаалалт	урьдчилан сануулах	гэмт хэрэг үйлдэхээр заналхийлсэн эсэхийг тогтоох тухайн этгээдэд хүлээлгэх ял шийтгэлийн талаар олж мэдэх мөрдөгч бичгээр урьдчилан сануулж, гарын үсэг зуруулна
			тодорхой үйлдлийг хязгаарлах	тодорхой үйлдлийг хязгаарлах арга хэмжээ авсан тухай мэдэгдэж гарын үсэг зуруулна
			биечилсэн хамгаалалт	хяналт тавина
			мэдээллийн нууцлалыг хангах	цагдаагийн харуул хамгаалалтын бүсэд хэрэгжүүлэхэд томилогдох цагдаагийн тоо, хугацааг тогтоох хамгаалалтад гарах
			нэг бүрийн тусгай хэрэгсэл болон тусгай техник хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгслээр хангах	мэдээллийн нууцлалыг хангахтай холбоотой байгууллага, албан тушаалтантай холбогдох бичиг явуулах
			аюулгүй газарт түр байрлуулах	нэг бүрийн тусгай хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгслээр хангах биед болон орон байранд тусгай техник хэрэгсэл суурилуулах
			нүүлгэн шилжүүлэх	аюулгүй байдал хангагдсан газарт бодит аюул, заналхийлэл арилах хүртэл хугацаанд түр байрлуулах
			баримт бичгийг солих	нүүлгэн шилжүүлэхэд түүний болон хамт амьдардаг гэр бүлийн гишүүдийн ажил, сургууль, амьдрах орон байр болон шаардлагатай бусад асуудлыг хамтад нь шийдвэрлэх иргэний бүртгэл, болон бусад холбогдох баримт бичгийг солиход албан тушаалтанд албан бичиг явуулах
			гадаад төрхийг өөрчлөх	гадаад төрхийг мэс заслын аргаар өөрчлөх үс засалт, үс, нүдний өнгийг өөрчлөх гэмт хэрэгт холбогдож байсан эсэх талаарх лавлагааг авах

	Сэтгэл зүйн хамгаалалт	гэрч, хохирогчийг хамгаалалтад авсан үеэс эхлэн шаардлагатай тохиолдолд сэтгэл зүйчийг байлцуулах	гэрч, хохирогчийг хамгаалалтад авах
			сэтгэл зүйчийг томилох
			сэтгэл зүйч нь гэрч, хохирогчтой уулзах
		гэрч, хохирогчийн оролцоотой явагдах мөрдөн шалгах ажиллагааны явцад үүсэх сэтгэл зүйн таагүй нөхцөл байдлын талаар урьдчилан мэдээлэх	мөрдөн шалгах ажиллагаа явуулах
			сэтгэл зүйн таагүй нөхцөл үүсэж буйг тогтоох
			үүссэн нөхцөл байдлыг мэдээлэх
		шүүх хуралдааны хугацаа, дараалал, явц болон нөхцөл байдлын талаар урьдчилан мэдээлэх	олж мэдэх мэдээлэх
			шүүх хуралдаан болох хугацаа, мэдээллийг авах
		шүүх хуралдааны танхимд гэрч, хохирогчтой сэтгэл зүйчийг хамт байлцуулах	сэтгэл зүйчийг томилох
			сэтгэл зүйч нь гэрч, хохирогчтой уулзах
	“Нийгмийн бусад туслалцаа”	шаардлагатай бусад арга хэмжээ.	сэтгэл зүйн зөвлөгөө өгөх
		Гэрч, хохирогчийг хүлээн авах үйл ажиллагаа эрсдэлийн түвшинг тодорхойлох гэрч, хохирогчийг эрсдэлийн түвшнээс шалтгаалан хамгаалах байр, бусад газарт хүргэж өгөх гэрч, хохирогчийг хүлээлгэн өгсөн тэмдэглэл үйлдэх	гэрч, хохирогчийг хүлээн авсан тэмдэглэл үйлдэх
		Хамгаалах байрны үйлчилгээ ² үйлчилгээний төлөвлөгөөг хамтран боловсруулах анхан шатны эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх, (эм бэлдмэлээр хангах) хоол, хүнсээр хангах номын сангийн үйлчилгээ үзүүлэх дэмжих бүлгийн ярилцлагад оруулах хууль зүйн анхан шатны зөвлөгөө өгөх нотлох бичиг баримт бүрдүүлэх бичиг баримттай холбоотой үйлчилгээ ³ сэтгэл зүйн анхан шатны зөвлөгөө өгөхмэдээ, мэдээллээр хангах сургалтад хамруулах	ариун цэврийн болон цагаан хэрэглэл олгох

Дээрх ЦЕГ-ын дэргэдэх Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн гүйцэтгэх үүрэг, стандарт үйл ажиллагааг хууль, дүрэм журамд зааснаар тодорхойлбол тус газрын аюулгүй байдлын хамгаалалт, сэтгэл зүйн хамгаалалт тодорхой хэмжээнд хэрэгжиж байдаг бөгөөд “нийгмийн бусад туслалцаа” үзүүлэх үйлчилгээг хуулийн төсөлд тусгасантай холбоотой зардлыг тооцох нь зүйтэй юм.

ХОЁР. АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭГ ГҮЙЦЭТГЭХ ХҮНИЙ НӨӨЦИЙГ ТОДОРХОЙЛОХ

Төсөл дэх төрийн байгууллагад хүлээлгэсэн үүргийг гүйцэтгэхэд шаардагдах ажил, үйлчилгээ тус бүрийг стандарт үйл ажиллагааны загварын дагуу тооцож, хэдий хэмжээний цаг хугацаа зарцуулахыг тогтоох юм. Хугацааг тодорхойлсноор тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэх хүний нөөцийн хэрэгцээг тогтоох бөгөөд улмаар улсын төсөвт хүний нөөцтэй холбоотой ямар хэмжээний зардал нэмэгдэхийг урьдчилан тооцох боломжтой.

Хүний нөөцийн хэрэгцээг тооцохдоо тухайн ажил, үйлчилгээг хэрэгжүүлэхэд зарцуулах хугацаа болон 1 жилд гүйцэтгэх тохиолдлын тоогоор баримжаалдаг.

Төрийн байгууллагын үйл ажиллагаа, ачааллын онцлогт тохирсон стандарт үйл ажиллагаа болон түүнд шаардагдах хугацааг нэгдсэн байдлаар тогтоосон зүйлгүй байна. Иймд стандартад тооцох тохиолдлын тоог ГХХтХ хэрэгжсэнээс хойш хамгаалалтад авсан цагдаагийн албаны дэргэдэх хамгаалалтад авсан иргэдийн сүүлийн 4 жилийн дундаж тоо, гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн сүүлийн 4 жилийн дундаж үзүүлэлтээр авч үзсэн.

2016 оны байдлаар гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл **94,324**, үүнээс эрүүгийн хэрэг үүсгэсэн гомдол, мэдээлэл 27,167, эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан материалын тоо 65,709 байна.⁵ Өөрөөр хэлбэл, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн тоо нь эрүүгийн хэрэг үүсгэсэн тооноос 3-4 дахин их байдаг боловч гагцхүү эрүүгийн хэрэг үүсгэсний дараа “хохирогч”-оор тогтоох тул гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн тоог авч үзсэн болно.

Хүснэгт 3. Гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн тохиолдлын тоо

Тохиолдол	2014 онд	2015 онд	2016 онд	2017 онд	Жилийн дундаж
Гэмт хэргийн улмаас хохирсон иргэд (Цагдаагийн байгууллагын статистик мэдээллийн дагуу)	27475	27948	27689	37173	30,071

Гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн дөрвөн жилийн дундаж үзүүлэлт нь 30,071 байна. Гэрч, хохирогчийг хамгаалах ажил нь зөвхөн цагдаагийн байгууллагад, эрүүгийн хэрэгт үүссэн гомдлоор шийдэгдэх бус шүүхийн байгууллагад шүүгч, прокурор хохирогчийг хамгаалалтад авах шийдвэрийг гаргаж болох хэдий ч хамгаалалтад авагдсан иргэдийн нэгдсэн мэдээлэл байхгүйгээс гэрч, хохирогчийн тоог бодитой гаргах боломжгүй, мөн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх шатанд хэчнээн хохирогч хамгаалалтад авагдаж байгаа, ТББ-ын болон бусад хамгаалах байранд байрлаж байгаа иргэдийн тоо тодорхойгүй байна. Иймд Эрүүгийн хэрэгт хохирсон нийт хохирогчийн тоог баримжаалан гаргавал илүү ойролцоо утгаар гарч болох юм.

Учир нь цагдаагийн байгууллагад гэрч, хохирогчийг хамгаалах хүний нөөц, материаллаг бааз, санхүүгийн нөөц бололцоо хангалттай биш байдгаас зайлшгүй хамгаалалтад авах шаардлагатай цөөхөн гэрч, хохирогчийг ЦЕГ-ын дэргэдэх Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэс авдаг байна.

⁵ Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном. Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, УБ., 2017 он, 43 дахь тал.

Хүснэгт 4. Хамгаалалтад авсан иргэдийн тохиолдлын тоо⁶

Тохиолдол	2014 онд	2015 онд	2016 онд	2017 онд	Жилийн дундаж
Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль хэрэгжсэнээс хойш хамгаалалтад авсан иргэд	34	85	42	36	49.25

ГХХтХ хэрэгжсэнээс хойш хамгаалалтад авсан иргэдийн жилийн дундаж нь 49.25 байх ажээ.

Гэмт хэргийн улмаас 30,071 иргэн хохирдог бол нэг байгууллагын хэмжээнд 49.25 иргэн хамгаалалтад авагдсан байна. ГХХтХ-ийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт “Энэ хуулийн зорилт нь гэмт хэрэг хянан шийдвэрлэх явцад гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, тэднийг мэдээллээр хангах, дэмжлэг, туслалцаа үзүүлэх эрх зүйн үндсийг тогтооход оршино” гэж заасан. Тиймээс урьдчилан сэргийлэх шатанд хохирогчийг хамгаалах “түр хамгаалах байр”, “нэг цэгийн үйлчилгээ” зэргээс ялгаатай байхаар зохицуулагджээ.

2.1. Зарцуулах хугацааг тодорхойлох

Авлигатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газар гэрч, хохирогчийг хамгаалах боловч энэ үйл ажиллагаа нь нууц байх тул 49.25 гэсэн тоогоор тохиолдлын тоог тооцох нь хангалтгүй төдийгүй ГХХтХ-ийн зорилтод зааснаар ирээдүйд хамгаалалтад авах иргэдийн тоо, зардал ачаалал нэмэгдэх нь зайлшгүй тул хамгаалалтад авагдсан иргэдээс гадна гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн тоог тохиолдлын тоо болгон авч үзэн хоёр янзаар хүний нөөцийн хэрэгцээг тодорхойллоо.

2.1.1. Хамгаалалтад авсан иргэдийн тохиолдлын тоотой холбогдон гарах анхан шатны үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийн хэрэгцээ*Хүснэгт 5. “Нийгмийн бусад туслалцаа” үзүүлэхэд шаардлагатай стандарт үйл ажиллагаа, зарцуулах хугацаа*

Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа /мин/	Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/
“Нийгмийн бусад туслалцаа үзүүлэх”	Гэрч, хохирогчийг хүлээн авах, тэмдэглэл үйлдэх	10	49.25	492.5
	Эрсдэлийн түвшинг тодорхойлох	15	49.25	738.75
	Хамгаалах байранд хүргэж өгөх	45 ⁴	49.25	2216.25
	Хүлээлгэн өгсөн тухай тэмдэглэл үйлдэх	10	49.25	492.5
	Ариун цэврийн болон цагаан хэрэглэл олгох	10	49.25	492.5
	Үйлчилгээний төлөвлөгөөг хамтран боловсруулах	15	49.25	738.75

⁶ Хамгаалалтад авсан иргэдийн тохиолдлын тоог ЦЕГ-ын дэргэдэх Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн буюу нэг байгууллагын хэмжээнд авсан.

Анхан шатны эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх, эм бэлдмэлээр хангах	20	49.25	985
Хоол, хүнсээр хангах	20	49.25	985
Номын сангийн үйлчилгээ үзүүлэх	30	49.25	1477.5
Дэмжих бүлгийн ярилцлагад оруулах	30	49.25	1477.5
Хууль зүйн анхан шатны зөвлөгөө өгөх	45	49.25	2216.25
Нотлох бичиг баримт бүрдүүлэх	25	49.25	1231.25
Сэтгэл зүйн анхан шатны зөвлөгөө өгөх	45 ⁵	49.25	2216.25
Мэдээ, мэдээллээр хангах	15	49.25	738.75
Сургалтад хамруулах	120	49.25	5910
Нийт	455	49.25	22,408.75

Дээрх хүснэгтээс үзвэл анхан шатны “нийгмийн бусад туслалцаа” үзүүлэхэд жилд дунджаар 22,408.75 минут буюу 373 ажлын цаг шаардагдахаар байна. Нэг албан хаагч 200 ажлын өдөр буюу 1600 цаг ажилладаг гэвэл 373 ажлыг цаг : 1600 цаг⁷ = 0.23 хүний нөөцийн хэрэгцээ шаардлагатай байна.

Иймд гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн тоог тохиолдлын тоо болгон авч хүний нөөцийн хэрэгцээг дараах байдлаар тодорхойлж үзлээ.

2.1.2. Хохирогч иргэдийн тоотой холбогдон гарах анхан шатны үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийн хэрэгцээ

Хүснэгт 6. “Нийгмийн бусад туслалцаа” үзүүлэхэд шаардлагатай стандарт үйл ажиллагаа, зарцуулах хугацаа

Гүйцэтгэх үүрэг	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа /мин/	Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/
“Нийгмийн бусад туслалцаа үзүүлэх”	Гэрч, хохирогчийг хүлээн авах, тэмдэглэл үйлдэх	10	30071	300710
	Эрсдэлийн түвшинг тодорхойлох	15	30071	451065
	Хамгаалах байранд хүргэж өгөх	45	30071	1353195
	Хүлээлгэн өгсөн тухай тэмдэглэл үйлдэх	10	30071	300710
	Ариун цэврийн болон цагаан хэрэглэл олгох	10	30071	300710
	Үйлчилгээний төлөвлөгөөг хамтран боловсруулах	15	30071	451065
	Анхан шатны эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх, эм бэлдмэлээр хангах	20	30071	601420
	Хоол, хүнсээр хангах	20	30071	601420
	Номын сангийн үйлчилгээ үзүүлэх	30	30071	902130

⁷ Нийт зарцуулах хугацаагаар хүний нөөцийн хэрэгцээ тодорхойлогдох ба тэрхүү хугацааг жилд ажиллах ажлын цагт хувааснаар шаардлагатай хүний нөөцийн хэрэгцээ буюу нэмэгдэх ажлын байрны тоо гарна.

Дэмжих бүлгийн ярилцлагад оруулах	30	30071	902130
Хууль зүйн анхан шатны зөвлөгөө өгөх	45	30071	1353195
Нотлох бичиг баримт бүрдүүлэх	25	30071	751775
Сэтгэл зүйн анхан шатны зөвлөгөө өгөх	45	30071	1353195
Мэдээ, мэдээллээр хангах	15	30071	451065
Сургалтад хамруулах	120	30071	3608520
Нийт	425	30071	13,682,305

Гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн тоогоор “нийгмийн бусад туслалцаа” үзүүлэхэд шаардлагатай анхан шатны туслалцаа үзүүлэх хүний нөөцийн хэрэгцээг тооцож үзвэл жилд дунджаар 13,682,305 минут буюу 228,038 ажлын цаг шаардагдахаар байна. Нэг албан хаагч 200 ажлын өдөр буюу 1600 цаг ажилладаг гэвэл 228,038 ажлын цаг : 1600 цаг = 142,5 хүний нөөцийн хэрэгцээ шаардлагатай болно.

ГУРАВ. ГАРАХ ЗАРДЛЫГ УРЬДЧИЛАН ТООЦООЛОХ

Төрийн байгууллагад буюу төрөөс гарах зардлыг урьдчилан тооцох үе шатанд:

- Хүний нөөцийн зардал (*төрийн албан хаагчтай холбоотой шууд болон шууд бусаар үүсэх зардал*)

- Материаллаг зардал (*төрийн албан хаагчийн ажлын байртай холбогдон гарах нийтлэг зардал*)

- Бусад зардал (*тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэхэд дагалдан гарах зардал*)-ыг тус тус тооцож гаргана.

1.1. Хүний нөөцийн зардал

Хүний нөөцийн зардлыг тооцохдоо тухайн ажил, үйлчилгээ буюу үүргийг гүйцэтгэх төрийн байгууллагын албан хаагчид зарцуулах цалин хөлс, нэмэгдэл, урамшуулал зэрэг төрөөс даадаг бүх зардлыг нэгтгэн авч үзэх ба эдгээрийн дундаж хэмжээгээр тооцож тогтоодог.

ЦЕГ-ын дэргэдэх Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэс нь нийт 30 албан хаагчтайгаар чиг үүргээ хэрэгжүүлдэг бөгөөд Төрийн тусгай албан хаагчийн ТТ-7 – ТТ-15 болон Төрийн үйлчилгээний албан хаагчийн ТҮ-1 зэрэглэлээр цалинждаг⁸ байна.

Хүснэгт 7. Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн албан тушаал, цол, цалингийн зэрэглэл, орон тоо

Д/д	Албан тушаал	Цолны зэрэглэл	Цалингийн зэрэглэл	Орон тоо
1	Хэлтсийн дарга	Цагдаагийн хурандаа	ТТ – 15	1
2	Тасгийн дарга	Цагдаагийн дэд хурандаа	ТТ – 13	2
3	Ахлах мэргэжилтэн	Цагдаагийн хошууч	ТТ – 12	1
4	Эрүүгийн ахлах мөрдөгч	Цагдаагийн хошууч	ТТ – 12	4
5	Эрүүгийн мөрдөгч	Цагдаагийн ахмад	ТТ – 11	12
6	Мэргэжилтэн	Цагдаагийн ахмад	ТТ – 10	1
7	Мэдээлэл, холбоо, сүлжээний инженер	Цагдаагийн ахмад	ТТ – 10	1
8	Сэтгэл зүйч	Цагдаагийн ахмад	ТТ – 10	2
9	Бичиг хэргийн эрхлэгч, архивч	Цагдаагийн ахлах ахлагч	ТТ – 7	1
10	Цагдаа – жолооч	Цагдаагийн ахлах ахлагч	ТТ – 7	3
11	Үйлчлэгч	Энгийн	ТҮ – 1	1

⁸ Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн А/136 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт “Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн албан тушаал, орон тоо, цол, цалингийн зэрэглэл”.

Дээр дурдсан албан хаагчдын цалингийн хэмжээг тооцохдоо Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн “Төрийн зарим албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай”⁹ 264 дүгээр тогтоолын 8 дугаар хавсралтыг үндэслэн 1 хүний дундаж цалингийн үнэлгээг гаргав. Ингэхдээ тухайн ажил, үүргийг гүйцэтгэдэг буюу “нийгмийн бусад туслалцааг” үзүүлэх үйлчилгээг хэрэгжүүлэх тус хэлтсийн Аюулгүй байдал, хамгаалалтын тасгийн албан хаагчдын цалингийн хэмжээг авч үзлээ.

Хүснэгт 8. Цалингийн зэрэглэл, хэмжээ

Цалингийн зэрэглэл	1	2	3	4	5	Дундаж цалин
ТТ – 12	617275	660766	702883	742150	782604	701,136₮
ТТ - 11	593701	635122	675231	712629	751158	673,568₮
ТТ - 10	571248	610696	648897	684515	721207	647,313₮
ТТ - 7	510107	544184	577182	607950	639647	575,814₮

Аюулгүй байдал, хамгаалалтын тасгийн нэг албан хаагчид зарцуулах, төрөөс даах зардлыг тооцохдоо түүнд олгох үндсэн цалингаас гадна (1) бүх төрлийн даатгал, (2) хоол, унааны нэмэгдэл, (3) ажилласан жилийн нэмэгдэл, (4) зэрэг дэвийн нэмэгдэл, (5) буцалтгүй тусламж, (6) шагнал, урамшуулал зэрэг нэмэлт зардлыг нэмж тооцох шаардлагатай байдаг.

Эдгээрийн хэмжээг тодорхой тогтоох боломжгүй тохиолдолд нэг албан хаагчийн цалингийн дундаж хэмжээний 30%-иар¹⁰ нэмэгдэл, урамшууллын зардлыг тооцож, нийтлэг болон дагалдах зардал болоод хүний нөөцийн нийт дундаж зардлыг дараагийн хүснэгтүүдээр тооцох болно. Ингэхдээ Хүснэгт 8-ын хүрээнд авсан цалингийн зэрэглэл тус бүрээр нэг албан хаагчид ногдох нэмэгдлийн мөнгөн дүнг тооцоолъё.

Хүснэгт 9. Нэг албан хаагчид ногдох цалингийн зардал /ТТ – 12 зэрэглэлийн дагуу/

Зардлын нэр	Цалингийн дундаж хэмжээ	Хувь	Хэмжээ /төгрөг/
Үндсэн цалингийн дундаж хэмжээ	701,136₮		701,136₮
Нэмэгдэл, урамшууллын зардал	701,136₮	30%	210,342₮
Нийт			911,478₮

Хүснэгт 10. Нэг албан хаагчид ногдох цалингийн зардал /ТТ – 11 зэрэглэлийн дагуу/

Зардлын нэр	Цалингийн дундаж хэмжээ	Хувь	Хэмжээ /төгрөг/
Үндсэн цалингийн дундаж хэмжээ	673,568₮		673,568₮
Нэмэгдэл, урамшууллын зардал	673,568₮	30%	202,071₮
Нийт			875,639₮

Хүснэгт 11. Нэг албан хаагчид ногдох цалингийн зардал /ТТ – 10 зэрэглэлийн дагуу/

Зардлын нэр	Цалингийн дундаж хэмжээ	Хувь	Хэмжээ /төгрөг/
Үндсэн цалингийн дундаж хэмжээ	647,313₮		647,313₮
Нэмэгдэл, урамшууллын зардал	647,313₮	30%	194,193₮
Нийт			841,506₮

⁹ Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 264 дүгээр тогтоол “Төрийн зарим албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай”, <http://legalinfo.mn/law/details/13631>, (сүүлд үзсэн 2018.10.12).

¹⁰ Хууль тогтоомжийн тухай хууль /аргачлал, гарын авлага/, Хууль зүй, дотоод хэргийн яам, GIZ, УБ., 2016 он, 286 дахь тал.

Хүснэгт 12. Нэг албан хаагчид ногдох цалингийн зардал /ТТ – 7 зэрэглэлийн дагуу/

Зардлын нэр	Цалингийн дундаж хэмжээ	Хувь	Хэмжээ /төгрөг/
Үндсэн цалингийн дундаж хэмжээ	575,814₮		575,814₮
Нэмэгдэл, урамшууллын зардал	575,814₮	30%	172,743₮
Нийт			748,557₮

Хүснэгт 13. Хүний нөөцийн дундаж зардал /1 жилээр¹¹/

Цалингийн зэрэглэл	Үндсэн цалин	Нэмэгдэл /30%/	Хоол, унаа/ өдөр	Хоол, унааны мөнгөн дүн	1 сарын цалин	12 сарын цалин	НДШ	Нийт /төгрөгөөр/
ТТ – 12	701,136	210,342	5000	110,000	1,026,478	12,317,736	1,354,950	13,672,686
ТТ – 11	673,568	202,071	5000	110,000	990,639	11,887,668	1,307,643	13,195,311
ТТ – 10	647,313	194,193	5000	110,000	956,506	11,478,072	1,262,587	12,740,659
ТТ – 7	575,814	172,743	5000	110,000	863,557	10,362,684	1,139,895	11,502,579
Нийт дундаж зардал								12,777,808₮

Ийнхүү дээрх хүснэгтүүдээс үзвэл Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн нэг албан хаагчид зэрэглэлээсээ хамаарч тодорхой хэмжээний ялгаатай зардал үүсэж буй бөгөөд хүний нөөцийн зардлын дундаж нь 1 албан хаагч 1 жилд 12,777,808 /арван хоёр сая долоон зуун далан долоон мянга найман зуун найм/ төгрөг авах юм.

1.2. Материаллаг зардал

Материаллаг зардал гэдэгт тухайн ажлын байртай холбоотой нийтлэг зардал буюу тухайн үүргийг гүйцэтгэж буй албан хаагчийг ажиллах нөхцөлөөр хангахад зарцуулж буй зардлыг хамааруулдаг. Тухайлбал, ажлын байр, эд хөрөнгө, техник хэрэгсэл, тэдгээрийн элэгдэл хорогдол, бусад ахуйн зардлыг тооцох шаардлагатай.

Тус зардлыг тооцохдоо “Хууль, хуулийн төслийн үр нөлөөг тооцох аргачлал”¹²-д үзүүлсэн Хууль зүй, дотоод хэргийн яамны нэг ажилтанд зарцуулагдах материаллаг зардлыг¹³ ашиглалаа.

¹¹ Хууль тогтоомжийн тухай хууль /аргачлал, гарын авлага/, Хууль зүй, дотоод хэргийн яам, GIZ, УБ., 2016 он, 286 дахь тал.

¹² Хууль, хуулийн төслийн үр нөлөөг тооцох аргачлал, Хууль зүй, дотоод хэргийн яам, GIZ, УБ., 2012 он, 97 дахь тал.

¹³ Гэвч тэрхүү материаллаг зардлын мөнгөн дүн нь 2012 оны тоон мэдээлэл болох тул агуулгыг удирдлага

Хүснэгт 14. Нэг албан хаагчид гарах материаллаг зардал /1 жилээр/

Зардлын нэр Урсгал зардал		Зардлын төрөл	Хэмжээ /төгрөг/
		Бичиг хэрэг	640,000₮
Зардлын нэр Урсгал зардал	Хангамж, бараа материалын зардал	Ном, хэвлэл	1,625,000₮
		Шуудан холбоо	306,812₮
		Гэрэл, цахилгаан, сантехник, бусад эд хогшлын холбогдолтой сэлбэг хэрэгсэл, гэрлийн шил, залгуур зэрэг6	1,800,000₮
		Цэвэрлэгээний материал7	960,000₮
		Нийт	7,331,812₮
	Байр, өрөө тасалгааны ашиглалттай холбоотой зардал	Түлш, халаалт	263,408₮
		Гэрэл, цахилгаан	128,239₮
		Цэвэр, бохир ус	599,438₮
		Урсгал засвар	127,752₮
		Нийт	1,118,837₮
Зардлын нэр Урсгал зардал	Урсгал засвар	Компьютер, тоног төхөөрөмжийн засвар	456,000₮
		Автомашин, засвар үйлчилгээ, тос масло8	2,000,000₮
		Нийт	2,456,000₮
	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	Автотээврийн хэрэгслийн татвар	185,000₮
		Автотээврийн утааны татвар	3500₮
		Газрын төлбөр	22,253₮
		Нийт	210,753₮
	Элэгдэл, хорогдлын зардал9	Техник, тоног төхөөрөмж10	160,000₮
		Тавилга, эд хогшил11	100,000₮
		Барилга, байгууламж12	65,670₮
		Нийт	325,670₮

Эдгээр зардлууд нийлээд “ажлын байрны ердийн дундаж материаллаг зардал”-ыг бүрдүүлнэ.

Хүснэгт 15. Ажлын байрны нийт дундаж материаллаг зардал /1 жилээр/

Ажлын байрны дундаж материаллаг зардал = 11,443,072₮	
Хангамж, бараа материалын зардал /7,331,812₮/ + Байр, өрөө тасалгааны ашиглалттай холбоотой зардал /1,118,837₮/ + Урсгал засвар /2,456,000₮/ + Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж /210,753₮/ + Элэгдэл хорогдлын зардал /325,670₮/	

Дээрхээс үзвэл Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн нэг албан хаагчид гарах материаллаг зардал нь жилд 11,443,072 /арван нэгэн сая дөрвөн зуун дөчин гурван мянга далан хоёр/ төгрөг байна.

1.3. Бусад зардал

Бусад зардалд тухайн ажил, үүргийг гүйцэтгэхэд дагалдан гарах зардлыг авч үздэг. Гэрч, хохирогчид “нийгмийн бусад туслалцаа”-г үзүүлэхэд дагалдан

болгон “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалын гарын авлага”-ын дагуу үнийн дүнг авч тооцов. Тус хавсралтын зарим агуулгыг мөн хүснэгтэд нэмсэн болно. (Хууль тогтоомжийн тухай хууль /аргачлал, гарын авлага/, Хууль зүй, дотоод хэргийн яам, GIZ, УБ., 2016 он, 287 дахь талаас үзнэ үү.)

гарах зардлыг энэ хэсэгт тооцоолох шаардлагатай бөгөөд тус зардлыг гаргахдаа Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2018 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн А/80 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх үйлчилгээнд хамрагдах иргэний тоо, шаардагдах хөрөнгийн хэмжээг тодорхойлох аргачлал”¹⁴-ыг баримжаалан шаардлагатай дүнг авч тооцсон болно.

Хүснэгт 16. Түр хамгаалах байранд байрлах нэг үйлчлүүлэгчид ногдох нэг хоногийн зардал

№	Зардлын төрөл	Хэмжээ /төгрөг/
1	Байр	2000₮
2	Хоол, цай	4000₮
3	Ариун цэвэр	600₮
4	Эрүүл мэндийн үйлчилгээ	2000₮
5	Нийгмийн ажлын үйлчилгээ	1000₮
6	Сэтгэл зүйн үйлчилгээ	2000₮
7	Аюулгүй байдлын үйлчилгээ	2000₮
10	Хууль зүйн зөвлөгөө	3000₮
11	Цэвэрлэгээ, үйлчилгээ ¹³	2,550
Нийт		19,150₮

Хүснэгт 17. Сургалтад хамрагдах нэг суралцагч (үйлчлүүлэгч)-д ногдох зардлын дээд хэмжээ

№	Зардлын төрөл	Ажлын 5 өдөр	Ажлын 10 өдөр
1	Бичиг хэрэг	2000₮	2000₮
2	Тараах материал, гарын авлага	2000₮	4000₮
3	Цайны зардал	3000₮	6000₮
4	Хоол, унааны мөнгө	8500₮	17,000₮
5	Дадлагын материал	3000₮	6000₮
Нийт		18,500₮	35,000₮

Хүснэгт 18. Бусад зардлын нийт хэмжээ

Зардлын төрөл	Зардлын хэмжээ
Түр хамгаалах байр /90 хоног/ ¹⁴	1,723,500₮
Бичиг баримттай холбоотой үйлчилгээ /1 хүн/ ¹⁵	79,600₮
Сургалтад хамруулах /Ажлын 10 өдөр/	35,000₮
Эмчийн үзлэг, бариа засал, эм тариа ¹⁶	42,000₮
Нийт	1,880,100₮

Ийнхүү “нийгмийн бусад туслалцаа” үзүүлэхэд шаардагдах бусад зардал буюу нэг үйлчлүүлэгчид ногдох нэг удаагийн нийт зардлын дээд хэмжээ 1,880,100₮ /нэг сая найман зуун наян мянга нэг зуу/ гэж тооцлоо.

ДӨРӨВ. ЗАРДЛЫГ НЭГТГЭН ТООЦОХ ҮЕ ШАТ

Энэ үе шатанд улсын төсвөөс гарах нийт зардлыг тооцож гаргах бөгөөд өмнөх үе шатанд тооцсон хүний нөөц, материаллаг зардал болон бусад зардлын

¹⁴ Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2018 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн А/80 дугаар тушаалын хавсралт, <http://hudulmur-halamj.gov.mn/uploads/document/5f826e04bbd963714254f01897cd357f2e6cb642.pdf> (сүүлд үзсэн 2018.10.12).

нийлбэрийг хүний нөөцийн хэрэгцээнд үржүүлснээр нийт зардал гарна.

Хүний нөөцийн хэрэгцээг тооцож гаргахдаа тохиолдлын тоог хоёр төрлөөр тооцсон тул зардлыг нэгтгэн тооцоходоо мөн хоёр төрлөөр гаргах шаардлагатай юм.

а/ Хамгаалалтад авсан иргэдийн тоотой холбогдон гарах нийт зардал

Хүснэгт 19. Нийт зардал

$(12,777,808\text{₮} / \text{хүний нөөцийн зардал} / + 11,443,072\text{₮} / \text{материаллаг зардал} / + 1,880,100\text{₮} / \text{бусад зардал} /) \times 0.23 / \text{хүний нөөцийн хэрэгцээ} / = 6,003,225.4\text{₮}$

ГХХтХ-ийн дагуу хамгаалалтын арга хэмжээ авсан иргэдийн тоогоор гарах зардлыг тооцоолоход **6,003,225.4₮** /зургаан сая гурван мянга хоёр зуун хорин тав аравны дөрвөн төгрөг/-ийн зардал “нийгмийн бусад туслалцаа” үзүүлэх нэг байгууллагын анхан шатны үйлчилгээнд гарах зардалд нэмж тусгах юм.

Түүнчлэн цаашид хамгаалалтад авах шаардлагатай гэрч, хохирогчийн тоо нэмэгдэх хандлагатай юм. Тухайлбал, шинээр байгуулагдсан гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэст хүний нөөц дутмаг, хууль хоорондын уялдаа холбоо хангалтгүй, хуулийн хэрэгцээ шаардлага зайлшгүй байгаа зэргийг харгалзан зөвхөн ЦЕГ-ын дэргэдэх нэг хэлтсийн хэмжээнд гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагаа явуулж байгааг Авилгатай тэмцэх газар, Тагнуулын байгууллагын дэргэдэх, болон бусад газарт /хөдөө орон нутагт/ дээрх мөнгөн дүнгээр зардлыг тусгах нь тохиромжтой бус юм. Иймд Хүснэгт 20-т гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн тоогоор гарах зардлыг тооцож үзлээ.

б/ Гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн тоогоор тооцоолсон нийт зардал

Хүснэгт 20. Нийт зардал

$(12,777,808\text{₮} / \text{хүний нөөцийн зардал} / + 11,443,072\text{₮} / \text{материаллаг зардал} / + 1,880,100\text{₮} / \text{бусад зардал} /) \times 142.5 / \text{хүний нөөцийн хэрэгцээ} / = 3,719,389,650\text{₮}$
--

Хүснэгтээс үзвэл гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн тоогоор гарах зардлын хэмжээг тооцоолоход 3,719,389,650₮ /гурван тэрбум долоон зуун арван есөн сая гурван зуун наян есөн мянга зургаан зуун тавин төгрөг/-ийн зардал гарах юм.

Төсөлд тусгасан “Нийгмийн бусад туслалцаа”-г гэрч, хохирогчид үзүүлэхэд төрийн байгууллага буюу ЦЕГ-ын дэргэдэх Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэст гарах зардлыг дээрх хэсгүүдэд тооцоолон гаргасан мөнгөн дүн, зардлын нийт хэмжээний дунджийг тооцоолох замаар гаргавал нэг жилд дунджаар 1,862,696,437.7₮ /нэг тэрбум найман зуун жаран хоёр сая зургаан зуун ерэн зургаан мянга дөрвөн зуун гучин долоо аравны долоон төгрөг/-ийн зардал ойролцоогоор үүсэх байна.

Ийнхүү дунджийг авч үзсэний учир нь (а) ГХХтХ хэрэгжиж эхэлснээс хойш хамгаалалтад авсан иргэдийн тоогоор зардлыг тооцох нь явцуу, учир дутагдалтай; (б) гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн тоо болох 30071 гэх тоогоор зардлыг тооцсон ч бүгд ГХХтХ-д заасны дагуу туслалцаа авахгүй. Иймд хоёр янзаар авч тооцсон зардлын дунджийг гаргасан 1,862,696,437.7₮/нэг тэрбум найман зуун жаран хоёр сая зургаан зуун ерэн зургаан мянга дөрвөн зуун гучин долоо аравны долоон төгрөг/-ийн гэх үзүүлэлт нь улсын төсөвт үүсэх ачаалал, зардлыг бодитоор магадлан харуулсан мөнгөн дүн гэж үзэж болох юм.

4.1. Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах

Энэ үе шатанд хуулийн төсөлд шинээр нэмэгдэж байгаа буюу өөрчлөгдөж буй зохицуулалттай холбоотой төрд үүсэх зардлыг багасгах, эдийн засагт дарамт

багатай өөр хувилбар, боломж байгаа эсэхийг шалгадаг. Ингэхдээ дараах хувилбар, боломжуудыг дэвшүүлэн шалгаж үзье. Үүнд:

- Төсвийн зардлыг багасгах боломж байгаа эсэх, зохицуулалтын өөр хувилбар байгаа эсэх;

- Хамгаалалтад авах шаардлагатай гэрч, хохирогчийн тоог багасгах, хүний нөөцийн хэрэгцээ, ачааллыг бууруулах боломж бий эсэх зэрэг болно.

Төсвийн зардлыг багасгах боломж, зохицуулалтын өөр хувилбар бий эсэх:

Хүний нөөцийг тодорхойлох үе шатанд дурдсанчлан нэг жилд дунджаар гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн тоо 30071 байхад хамгаалалтад авсан иргэдийн тоог 49.25 буюу нэг байгууллагын хэмжээнд тооцоолсон нь харьцангуй бага тоо юм. Мөн хүч хэрэглэсэн гэмт хэргийн улмаас хохирсон 1199 хохирогч, 3597 гэрчийг хамгаалах шаардлагатай¹⁵ (2014 оны тооцоолол) гэсэн тооцоо байдаг ажээ.

Ийнхүү тохиолдлын тоог гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн тоогоор авсны учир нь төсөл батлагдаж, “нийгмийн бусад туслалцаа”-ны асуудал шийдэгдсэнээр, ГХХтХ-ийн зорилтыг хангах үүднээс хамгаалалтад авах шаардлагатай иргэдийн тоо нэмэгдэх хандлага ажиглагдаж байгаа учир өргөн хүрээнд зардлыг тооцох нь зүйтэй. Судалгааны тайлангийн дүнгээс үзвэл гэрч, хохирогчид нийгмийн туслалцаа үзүүлэхэд жилд дунджаар 1,862,696,437.7₮ /нэг тэрбум найман зуун жаран хоёр сая зургаан зуун ерэн зургаан мянга дөрвөн зуун гучин долоо аравны долоон төгрөг/-ийн зардал ойролцоогоор үүсэж байна.

Гадаадын зарим орнуудын /9 улс/ гэрч, хохирогчийг хамгаалах ажлын талаар судлан үзсэн ажлын дүгнэлтэд, “улс орон бүрийн амьдралын хэв маяг, амьжиргааны түвшин нь харилцан адилгүй боловч судалгаанд хамрагдсан улсуудын тухайн ажиллагаанд (хамгаалалтад авсан, туслалцаа үзүүлсэн иргэнд) зарцуулж буй жилийн төсөвлөгдсөн хөрөнгийн дундаж үзүүлэлт нь 12,249,000 ам.долларыг 763 хүнийг хамгаалахад зарцуулдаг¹⁶” гэжээ. Үүнийг монгол төгрөгт шилжүүлэн тооцвол¹⁷ 31,413,172,950 /гучин нэгэн тэрбум дөрвөн зуун арван гурван сая зуун далан хоёр мянга есөн зуун тавин төгрөг/ болж байна.

Иймд хамгаалалтад авах шаардлагатай иргэдийн тооноос хамааруулан төсөвт үүсэх зардлыг тодорхой хэмжээгээр багасгаж болох хэдий ч төсвийн зардлыг бууруулах шалтгаан, зохицуулалтын өөр хувилбар эрэлхийлэх нь төдийлөн оновчтой биш байна.

Хамгаалалтад авах шаардлагатай гэрч, хохирогчийн тоог багасгах, хүний нөөцийн хэрэгцээ, ачааллыг бууруулах боломж бий эсэх:

Хамгаалалтад авах шаардлагатай гэрч, хохирогчийн тоо уг судалгаанд туссан хохирсон иргэдийн тоотой харьцуулан үзвэл бага байх тул гэрч, хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөхгүйгээр эдийн засгийн хувьд үр ашигтай байх зарчмыг баримтлах, боломжтой арга замыг эрэлхийлэх нь чухал юм. Өөрөөр хэлбэл, эрүүл мэндийн туслалцаа үзүүлэх, сэтгэл зүйн туслалцаа үзүүлэх, хууль зүйн туслалцаа үзүүлэх мэргэжлийн багт даатгах, аюулгүй байдлын хамгаалалтыг мөн адил, нэг цэгийн үйлчилгээ, бусад хамгаалах байруудын үйлчилгээтэй нэгтгэн зохицуулах, нийгмийн тусламж үйлчилгээг Нийгмийн халамжийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулж болох юм.

¹⁵ М.Ичинноров, “Гэрч, хохирогчийг төрийн нэрийн өмнөөс хамгаалах нь эрх зүйн шинэтгэлийн чухал алхам мөн” Хууль сахиулахуйн инноваци олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ., 2014 он, 56 дахь тал.

¹⁶ Э.Болор-Эрдэнэ, “Гэрч, хохирогчийг хамгаалах ажиллагааны зардал” Гэрч, хохирогчийг хамгаалах тогтолцоо, түүний эрх зүйн орчинг боловсронгуй болгох нь сэдэвт хэлэлцүүлэг – илтгэлийн эмхэтгэл, 2016 он, 50 дахь тал.

¹⁷ Монгол Улсын төв банк болон Монгол банкнаас 2018.10.30-ны өдөр зарласан ханшийн дагуу нэг ам.доллар нь 2,564.55₮ байна. <https://www.mongolbank.mn/dblistofficialdailyrate.aspx> (сүүлд үзсэн 2018.10.30).

Тухайлбал, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 12 дугаар зүйлд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба хохирогчийг хамгаалах ажиллагааг явуулж байгаатай хамтрах, Дотоодын цэргийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6-д гэрч, хохирогчийг хамгаалах тухай, Эрүүл мэндийн үнэ төлбөргүй үйлчилгээг нэг цэгийн үйлчилгээгээр үзүүлж байгаа, хууль зүйн зөвлөгөөг үнэ төлбөргүй Хууль зүйн туслалцааны төв өгч байгаа, сэтгэл зүйн үйлчилгээг нийгмийн хамгааллын үйлчилгээгээр дамжуулан авах, сэтгэл заслын үйлчилгээг эрүүл мэндийн байгууллагаар дамжуулан авах зэрэг хууль тогтоомжоор нэгэнт хэрэгжиж байгаа үйл ажиллагааг дэмжин түүнд эрсдэлийн түвшин өндөртэй гэрч, хохирогчийг хэрхэн хамгаалах эрх зүйн зохицуулалтыг нэмж тусган гэрч, хохирогчийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бусад хуулийн этгээдүүд¹⁸ хууль буюу гэрээний үндсэн дээр “нийгмийн бусад туслалцаа” үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэхэд төрийн байгууллага болон хуулийн этгээдүүдийн хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулан, хувь хүний нууц, байгууллагын нууц, аюулгүй байдлыг хангах ажиллагааг нэмэгдүүлэн сайжруулснаар ачаалал тодорхой хэмжээнд буурах боломжтой.

Гэрч, хохирогчийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулах чиг үүрэг бүхий гол байгууллага болох ЦЕГ-ын дэргэдэх Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэс “Түр хамгаалах байр”-ны хүрэлцээ муутайгаас гагцхүү гэр бүлийн хүчирхийллийн болон эрсдэлийн түвшин бага гэрч, хохирогчдыг НЦГ-ын дэргэдэх “Түр хамгаалах байр”, ХЭҮТ-ийн байруудад тус тус хүргэж өгдөг байна. Иймд цаашид Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэс нь уялдуулан холбох чиг үүрэгтэй байхаар, зайлшгүй шаардлагатай эрсдэлийн түвшин өндөр гэрч, хохирогчийг хамгаалалтад авч байх зохицуулалтыг бий болгосноор ачаалал тодорхой хэмжээнд буурч болох юм.

Түүнчлэн гэмт хэргийн гэрч, хохирогчид үзүүлэх “нийгмийн бусад туслалцаа”-г төр хариуцах нь тодорхой асуудал. Мөн хохирогчид олгох нөхөн төлбөрийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар зохицуулсан боловч хохирол учруулсан этгээдээс гаргуулах нөхөн төлбөрийг төрийн санд хэрхэн төвлөрүүлэх талаар нарийвчилсан зохицуулалт байхгүй байна. ГХХтХ-ийн 26 дугаар зүйлийн 26.1-д “Гэмт хэргийн хохирогчид Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 213 дугаар зүйлд заасан журмын дагуу нөхөн төлбөр олгоно” гэж, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн “Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан” хэмээх 213 дугаар зүйлийн 213.3-т “Гэмт хэргийн хохирогчид олгох нөхөн төлбөрийн хэмжээ нь хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэх тухай шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр тодорхойлогдоно” гэж тус тус заасан байна. Гэвч хуульд заасан байгууллага хоорондын уялдаа холбоо хангалтгүй байдгаас тус зохицуулалт практикт хэрхэн хэрэгжих нь тодорхойгүй байна. Угтаа тус заалт хэрэгжсэн тохиолдолд гэрч, хохирогчид “нийгмийн бусад туслалцаа” үзүүлсэн зардлын тодорхой хувийг тэрхүү нөхөн төлбөрөөс суутгах зэрэг гарцыг эрэлхийлэх замаар асуудлыг шийдвэрлэх боломжтой болох юм.

1.2. Үр дүн

Төсөлд шинээр тусгагдсан “нийгмийн бусад туслалцаа”-г үзүүлэхэд төрийн байгууллагад буюу улсын төсөвт үүсэх зардлыг урьдчилсан байдлаар тооцоолов. Ингэхдээ тохиолдлын тоог хоёр янзаар авч үзэн тусад нь тооцсон болно.

Тийнхүү тусад нь авч үзсэний үндсэн дээр гарсан тооцоог нэгдсэн байдлаар дурдвал:

¹⁸ ТББ-ууд болон тэдгээртэй төстэй бусад хуулийн этгээдүүд.

а/ ГХХтХ-ийн дагуу хамгаалалтад авсан иргэдийн тоогоор гарах зардлыг тооцоолоход 6,003,225.4₮ /зургаан сая гурван мянга хоёр зуун хорин тав аравны дөрвөн төгрөг/-ийн зардал, 0.23 хүний нөөцийн хэрэгцээ;

б/ гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн тоогоор гарах зардлын хэмжээг тооцоолоход 3,719,389,650₮ /гурван тэрбум долоон зуун арван есөн сая гурван зуун наян есөн мянга зургаан зуун тавин төгрөг/-ийн зардал, 142.5 хүний нөөцийн хэрэгцээ тус тус үүсэж байна.

Дээрхээс үзэхэд ГХХтХ-ийн дагуу хамгаалалтын арга хэмжээ авсан иргэдийн тоогоор зардлыг тооцоолох нь улсын төсөвт үүсэх зардал, ачаалал харьцангуй бага байна. Харин гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн тоог тохиолдлын тоо болгон зардлыг тооцож тэдгээрийн дунджийг тооцоолсноор “нийгмийн бусад туслалцаа”-г үзүүлэх төрийн байгууллагад буюу улсын төсөвт жилд дунджаар 1,862,696,437.7₮/ нэг тэрбум найман зуун жаран хоёр сая зургаан зуун ерэн зургаан мянга дөрвөн зуун гучин долоо аравны долоон төгрөг/-ийн зардал, 71.3 хүний нөөцийн хэрэгцээ үүсэх магадлалтай байна.

Түүнчлэн ГХХтХ-тай холбогдуулан гаргасан Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаал¹⁹ хэрэгжиж буй хэдий ч мөн хуулийн 18 дугаар зүйлд заасан туслалцаатай холбоотой зохицуулалтыг нарийвчлан дэлгэрүүлсэн журам, ялангуяа төсөлд тусгасан “нийгмийн бусад туслалцаа”-нд хамаарах үйл ажиллагаа, тэдгээрийн стандартыг төрөлжүүлэн жагсаасан журам батлах шаардлагатай юм.

ТАВ. ДҮГНЭЛТ

Төслийн зардлын тооцоог хийх нь хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх явцад иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад хэдий хэмжээний зардал, ачаалал үүсгэхийг урьдчилан гаргах зорилготой байдаг.

Төсөлд иргэн, хуулийн этгээдэд үүрэг хүлээлгэсэн зохицуулалтгүй бөгөөд зардлын тооцоог хийх судалгааны хүрээнд болон төрийн байгууллагад үүсэх зардлыг урьдчилсан байдлаар тооцов. Ингэхдээ зардал үүсгэх боломжтой зүйл, заалт буюу төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт тус тус заасан “нийгмийн бусад туслалцаа”-тай холбогдон гарах зардлын тооцоог хийлээ.

ГХХтХ болон төсөлд хуулийн этгээдэд шууд байдлаар үүрэг хүлээлгэсэн зохицуулалт байхгүй, гагцхүү төрийн байгууллагад үүрэг болгосон хэдий ч практикт гэрч, хохирогчид “нийгмийн бусад туслалцаа” үзүүлэх хүрээнд хуулийн этгээд, ТББ тодорхой үүрэгтэй оролцдог. Тус чиг үүргийг хэрэгжүүлэх гол эрх бүхий байгууллага болох ЦЕГ-ын дэргэдэх Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэс нь шаардлагатай тохиолдолд хамгаалалтад авагдсан гэрч, хохирогчийг НЦГ-ын дэргэдэх Түр хамгаалах байр болон ТББ-ын түр хамгаалах байранд хүргэж өгдөг.

Иймд төрийн байгууллагад үүсэх зардлыг тооцохдоо ГХХтХ-ийн дагуу хамгаалалтад авсан иргэдийн тоо буюу нэг байгууллагын зардлаар улсын төсөвт үүсэх зардал, ачааллыг гаргах боломжгүй тул гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн тоог авч тэдгээрийн дунджийг тооцоолсноор гэрч, хохирогчид туслалцаа үзүүлэхэд шаардлагатай нийт мөнгөн дүн буюу улсын төсөвт үүсэх зардал ойролцоогоор 1,862,696,437.7₮ /нэг тэрбум найман зуун жаран хоёр сая зургаан зуун ерэн зургаан мянга дөрвөн зуун гучин долоо аравны долоон төгрөг/ байна гэж үзлээ. Өөрөөр хэлбэл, одоогийн байдлаар Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэс дэх хамгаалалтад авсан иргэдийн тоогоор зардлыг тооцоолох нь улсын төсөвт үүсэх зардлыг бодитоор тооцох үндэслэл болж чадахгүй бөгөөд Монгол Улсын хэмжээнд

¹⁹ Эх сурвалжийн жагсаалтаас харна уу.

хамгаалалтад авсан иргэдийн тоог бүхэлд нь тооцох боломжгүй байх тул гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн тоотой харьцуулан дунджийг гаргалаа.

Энэ нь улсын төсөвт тодорхой хэмжээний ачаалал үүсгэх хэдий ч гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагаа нь багагүй зардлыг шаарддаг. Шаардлагатай туслалцааг зүй ёсоор үзүүлэх нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэний эрхийг баталгаатай эдлүүлэх, ГХХтХ-ийн зорилтыг хангахад чиглэсэн чухал алхам юм. Гэвч нөгөө талаас, энэхүү зардлын мөнгөн дүнг эргээд ямар замаар эргэн төвлөрүүлэх, төсөвт ашигтай байдлаар зохицуулах тухай асуудал бодитоор урган гарна.

Ийнхүү судалгааны үр дүнгээс дараах саналыг гаргаж байна. Үүнд:

- Гэрч, хохирогчийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг буюу гэрч, хохирогчид “нийгмийн бусад туслалцаа” үзүүлдэг хуулийн этгээдэд гэрээний үндсэн дээр тус чиг үүргийг хэрэгжүүлэх эрхийг эрх зүйн зохицуулалтад /Гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөрийн 5 дугаар зүйлийн 5.2.1-д “гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх чиглэлээр төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагын хэрэгжүүлж байгаа зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх” гэж тусгасан/ тусгаж өгснийг хэрэгжүүлэх, тодорхой хэмжээний төсвийг төрөөс санхүүжүүлэх,

- ГХХтХ, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль болон бусад хуулийн уялдаа холбоог нягтлах, нарийвчилсан зохицуулалт бий болгох буюу гэрч, хохирогчид “нийгмийн бусад туслалцаа” үзүүлэхэд зарцуулагдсан зардлыг эргээд хэрхэн төвлөрүүлэх талаар арга зам, боломжит хувилбарыг эрэлхийлэх;

- ГХХтХ-д заасан гэрч, хохирогчид туслалцаа үзүүлэх тусгай алба болон энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээд хоорондын хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулах үүднээс бодитой алхмуудыг шат дараатай хэрэгжүүлэх,

- Гэрч, хохирогчид туслалцаа үзүүлэх ажиллагаатай холбогдсон стандарт үйл ажиллагааны жагсаалт, “нийгмийн бусад туслалцаа”-г нарийвчлан тодорхойлсон журам батлах,

- ЦЕГ-ын дэргэдэх Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн үйл ажиллагааг өргөжүүлэн сайжруулах, одоо ажиллаж буй түр хамгаалах байрны хүчин чадал, нөөц бололцоог нэмэгдүүлэх, уялдаа холбоог хангах,

- Гэрч, хохирогчийг хамгаалах ажлыг бүхэлд нь “хэрэг хянан шийдвэрлэх явцад” авч байгаа нь гэрч, хохирогчийг хамгаалах ажиллагааг хүндрүүлж байх тул урьдчилан сэргийлэх шатанд авч буй хамгаалах ажиллагаатай уялдуулах шаардлагатай байна.

ЭХ СУРВАЛЖ

НЭГ. ЭРХ ЗҮЙН АКТ

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

1. Авлигын эсрэг НҮБ-ын конвенц
2. Арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц
3. Дипломат харилцааны тухай венийн конвенц
4. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт
5. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай конвенц
6. Консулын харилцааны тухай венийн конвенц
7. Монгол, Хятадын хилийн дэглэмийн тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын гэрээ

8. Терроризмын зорилгоор бөмбөг хэрэглэхийг хориглох тухай олон улсын конвенц

9. Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц

10. Хүүхдийн эрхийн тухай конвенц

11. Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг хүүхдийн эрхийн тухай конвенцид оруулах нэмэлт протокол

12. Хүн барьцаанд авахын эсрэг олон улсын конвенц

13. Олон Улсын гэрээний тухай венийн конвенц

14. Олон Улсын шүүхийн дүрэм

15. Олон Улсын эрүүгийн шүүхийн ромын дүрэм

16. Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн тухай олон улсын пакт

17. Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн нэмэлт протокол

18. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1. Авлигын эсрэг хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2006 он, №35

2. Архивын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1998 он, №2

3. Байгууллагын нууцын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1995 он, №7

4. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1998 он, №1

5. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2013 он, №30

6. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль /шинэчилсэн найруулга/, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2017 он, №5

7. Гүйцэтгэх ажлын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1998 он, №3

8. Даатгалын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2004 он, №20

9. Дипломат албаны тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2000 он, №39

10. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2011 он, №8

11. Дотоодын цэргийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2017 он, №12

12. Жолоочийн даатгалын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2011 он, №43

13. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2015 он, №28

14. Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2006 он, №27

15. Захиргааны ерөнхий хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2015 он, №28

16. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль /шинэчилсэн найруулга/, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2016 он, №9

17. Зөрчлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2017 он, №24

18. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2017 он, №24

19. Иргэний хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2002 он, №7

20. Иргэний бүртгэлийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1999 он, №49 /2018 оны 11 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчингүй болсонд тооцно./

21. Иргэний улсын бүртгэлийн тухай хууль /шинэчилсэн найруулга 2018 оны 6 дугаар сарын 21-ны өдөр баталсан/, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2018 он, №28
22. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2002 он, №8
23. Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1992 он, №1
24. Монгол Улсын Хилийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2017 он, №6
25. Монгол Улсын Шүүхийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2012 он, №11
26. Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2004 он, №16
27. Монголын Улаан загалмай нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2016 он, №5
28. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2011 он, №26
29. Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1994 он, №8
30. Нийгмийн халамжийн тухай хууль /шинэчилсэн найруулга/, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2012 он, №8
31. Прокурорын тухай хууль /шинэчилсэн найруулга/, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2017 он, №24
32. Тагнуулын байгууллагын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1999 он, №35
33. Татварын ерөнхий хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2008 он, №22
34. Төрийн албаны тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2002 он, №28
35. Төрийн болон албаны нууцын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2017 он, №11
36. Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2003 он, №2
37. Улсын бүртгэлийн ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2009 он, №26
38. Үндсэн хуулийн цэцийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1992 он, №3
39. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1997 он, №6
40. Хохирлыг эргэн төлөгдөх нөхцөлөөр барагдуулах тухай, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2007 он, №32
41. Хохирогчид нөхөх олговор олгох тухай, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2009 он, №28
42. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2016 он, №9
43. Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1999 он, №25
44. Хувь хүний нууцын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1995 он, №7
45. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2012 он, №11
46. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2015 он, №8
47. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2012 он, №7

48. Хүнсний тухай хууль /шинэчилсэн найруулга/, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2013 он, №2

49. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2013 он, №2

50. Хүүхэд хамгааллын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2016 он, №9

51. Цагдаагийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2017 он, №8

52. Цэргийн албаны тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2016 он, №36

53. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль /шинэчилсэн найруулга/, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2017 он, №24

54. Шүүхийн шинжилгээний тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2010 он, №2

55. Эрүүл мэндийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2011 он, №21

56. Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2015 он, №8

57. Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2016 он, №7

58. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /шинэчилсэн найруулга/, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2017 он, №23

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1. Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”

2. Улсын Их Хурлын 2016 оны 11 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”

3. Үндсэн хуулийн цэцийн 2014 оны 1 дүгээр дүгнэлтийн тухай /дугаар 21/

4. Хуулийн төслийг буцаах тухай /дугаар 20/

5. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар авах зарим арга хэмжээний тухай 2013 оны /дугаар 20/

ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1. Гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр, Засгийн газрын 2015 оны 346 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

2. Хохирогчид нөхөх олговор олгох журам батлах тухай, Засгийн газрын 2009 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн дугаар 294 тогтоол

3. Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай, 2017 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн дугаар 115 /Засгийн газрын 2015 оны 346 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах тухай/

УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

1. 2003 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн Улсын дээд шүүхийн тогтоол №02, Прокурорын байгууллагын тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай

2. 2009 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн Улсын дээд шүүхийн зөвлөмж №04, Давж заалдах шатны шүүх хуралдаан, иргэний хэргийг хянан хэлэлцэх давж заалдах шатны шүүхийн ажиллагааны онцлог

3. 2007 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн Улсын дээд шүүхийн тогтоол №15, Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай

4. 2006 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн Улсын дээд шүүхийн тогтоол №47, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн зарим зүйл заалтыг тайлбарлах тухай

5. 1997 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн Улсын дээд шүүхийн тогтоол №318, Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянах тухай, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл, хэсэг заалтыг тайлбарлах тухай

6. 2008 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн Улсын дээд шүүхийн зөвлөмж, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаан дахь гэрчийн мэдүүлэг

7. 2007 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн Улсын дээд шүүхийн зөвлөмж, Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянах тухай

8. 2016 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн Улсын дээд шүүхийн зөвлөмж, Эрх зүйн маргаантай харилцааг тогтоох, хуулийн холбогдох зохицуулалтыг зөв тайлбарлан хэрэглэх шүүгчийн ажиллагаа

9. 2008 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн Улсын дээд шүүхийн зөвлөмж, яллагдагч, шүүгдэгчийн мэдүүлгийг үнэлэх асуудлын тухай

ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ШИЙДВЭР

1. 2005 оны 3 дугаар сарын 31-ны өдрийн Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай дүгнэлт, №2

2. 2006 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай дүгнэлт, №1

3. 2018 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 8 дахь хэсэг, 9.2 дугаар зүйлийн 13 дахь хэсэг нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай дүгнэлт, №9

4. 2016 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим зүйл Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай дүгнэлт, №7

5. 2018 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1.5 дахь заалт, 118 дугаар зүйлийн 118.5 дахь хэсгийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай дүгнэлт, №2

6. 2018 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хууль, Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай дүгнэлт, №7

7. 2005 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн Прокурорын байгууллагын тухай хуулийн зарим заалт үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай дүгнэлт, №5

8. 2015 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай дүгнэлт, №15

9. 2016 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай дүгнэлт, №15

10. 2018 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.2 дахь заалт үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэх дүгнэлт, №8

САЙДЫН ТУШААЛ

1. Гадаад харилцааны сайдын 2013 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дугаар А/91 тушаал, Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх журам

2. Хөдөлмөрийн сайдын 2015 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн дугаар А/135 дугаар тушаал, Хохирогчийг ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах үйлчилгээ үзүүлэх журам

3. Хууль зүй, дотоод хэргийн сайдын үүрэг гүйцэтгэгчийн 2014 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/112 дугаар тушаал, Биечилсэн хамгаалалтын журам /Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 7.1.3/

4. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2014 оны 7 дугаар сарын 02-ны өдрийн А/112 дугаар тушаал, Гэрч, хохирогчийг мэдээллийн нууцлалыг хангах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журам /Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 7.1.4/

5. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2014 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн А/113 дугаар тушаал, Гэрч, хохирогчийг тусгай техник хэрэгслийн жагсаалт, хэрэгслээр хангах, хэрэглэх журам /Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 7.1.5/

6. Хууль зүй, дотоод хэргийн сайд сайдын 2014 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн А/114 дүгээр тушаал, Гэрч, хохирогчийг аюулгүй газарт түр байрлуулах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журам /Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 7.1.6/

7. Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, эрүүл мэндийн сайдын хамтарсан 2017 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн дугаар А/84, /А/59/, А/130 дугаар тушаал, Хохирогчид үйлчилгээ үзүүлэх төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэх журам

8. Эрүүл мэндийн сайд, Хууль зүйн сайдын хамтарсан 2014 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн А/250, А-171 дугаар тушаал, Гэрч, хохирогчид эрүүл мэндийн туслалцаа үзүүлэх журам /Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 18.1.3/

9. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн А/74 дүгээр тушаал, Сэтгэл зүйн зөвлөгөө үзүүлэх журам

10. Эрүүл мэндийн сайдын 2017 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн А/394 дүгээр тушаал, Хохирогчид сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх журам

11. Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн А/80, А/132, А/60, Нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх санхүүжүүлэх журам

АЙМАГ, НИЙСЛЭЛ ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР

1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай 2008 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн №59

ХОЁР.НОМ, ГАРЫН АВЛАГА

1. Ч.Нямсүрэн “Гэмт хэргийн хохирогчийн эрх зүйн байдал” докторын ажил, 2013 он.

2. Ч.Нямсүрэн “Гэмт хэргийн виктимологи: хохирогч судлал”, 2005 он.

3. “Гэрч, хохирогчийг хамгаалах тогтолцоо, түүний эрх зүйн орчинг боловсронгуй болгох нь” сэдэвт хэлэлцүүлгийн илтгэлийн эмхэтгэл. 2016 он.

4. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан. 2018 он.

5. Монголын төр, эрх зүй №1 (87), 30 дахь тал, Х.Оюунжаргал “Гэрч, хохирогчийг хамгаалах асуудал”, 2017 он.

6. Монголын төр, эрх зүй №3 (73), 26 дахь тал, Д.Тайванхүү “Хохирогчийн эрх зүйн байдал”, 2017 он.

7. Монголын төр, эрх зүй №3 (73), 30 дахь тал, Г.Намуунзул “Хохирогчийн эрхийг хамгаалахад тулгамдаж буй асуудал”, 2017 он.

8. Монголын төр, эрх зүй №3 (73), 36 дахь тал, Ш.Оюунханд “Сэтгэл санааны хохирол ба Олон Улсын хэм хэмжээ”, 2017 он.

9. Монголын төр, эрх зүй №4 (89), 16 дахь тал, Д.Энх-Амгалан “Гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт, тулгамдаж буй асуудал”, 2017 он.

10. Монголын төр, эрх зүй №4 (90), 18 дахь тал, “Гэмт хэргийн хохирогчид учирсан сэтгэл санааны хохирлыг арилгах хууль зүйн үндэслэлийн зарим асуудал” 2017 он.

11. Монголын төр, эрх зүй №4 (90), 28 дахь тал “Гэрч, хохирогч хүүхдийн эрх ашгийг хамгаалах олон улсын эрх зүйн зохицуулалт хамгаалалтын уламжлал шинэчлэлийн асуудал”, 2017 он.

12. “Орчин үеийн эрх зүйн тулгамдсан асуудлууд” эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл, 216 дахь тал, Г.Лхагвасүрэн “Гэмт хэргийн улмаас нийгэм, иргэдэд учирсан хохирлыг төрөөс барагдуулах эрх зүйн зохицуулалтын асуудал”, 2015 он.

13. “Орчин үеийн эрх зүйн тулгамдсан асуудлууд” эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл, 317 дахь тал, М.Доржсүрэн “Гэмт хэргийн сэтгэл санааны хохирол”, 2015 он.

14. Тодорхой төрлийн гэмт хэрэг мөрдөх аргачлал /хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч болон судлаач, оюутнуудад зориулсан гарын авлага/ 23 дахь тал, Гэмт этгээд, хохирогчийн хувийн байдлыг тогтоох ажиллагаа, 2016 он.

15. Үндсэн хуулийн эрх зүйн тулгамдсан асуудал: онол, арга зүй, хэрэгжилт, 23 дахь тал, “Үндсэн хуулийн цэц үндсэн хуулиар баталгаажсан иргэний эрхийг хамгаалж ирсэн нь”, 2017 он.

16. “Хууль сахиулах үйл ажиллагаа: онол практикийн тулгамдсан асуудал” олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, 205 дахь тал, Л.Галбаатар “Гэрч, хохирогчийг хамгаалах тогтолцоо, эрх зүйн орчин боловсронгуй болгоход тулгамдаж буй асуудлууд”, 2016 он.

17. “Хууль сахиулах үйл ажиллагаа: онол практикийн тулгамдсан асуудал” олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, 231 дахь тал, Ц.Дулмаа “Монгол Улсад эрх нь хамгийн их зөрчигдсөн хүмүүс бол гэмт хэргийн хохирогчид”, 2016 он.

18. “Хууль сахиулах үйл ажиллагаа: онол практикийн тулгамдсан асуудал” олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, 238 дахь тал, Элико Циклаури Ламмих “Тодорхой үзэгдэл болох хүчирхийлэл, түүний илрэх хэлбэрүүд” Феномен насалия- Формы её проявления, 2016 он.

19. “Хууль сахиулах үйл ажиллагаа: онол практикийн тулгамдсан асуудал” олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, 265 дахь тал, Г.Баттулга “Гэрч, хохирогчийг хамгаалах тогтолцоо, эрх зүйн орчны боловсронгуй болгоход тулгамдаж буй асуудлууд”, 2016 он.

20. “Хууль сахиулахуйн инноваци” олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл 54 дахь тал, М.Ичинноров “Гэрч, хохирогчийг төрийн нэрийн өмнөөс хамгаалах нь эрх зүйн шинэтгэлийн чухал алхам мөн”, 2014 он.

21. “Хууль сахиулахуйн инноваци” олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, 85 дахь тал, Э.Өлзийлхам “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалахад хүний эрхэд суурилсан хандлагыг авч үзэх хууль сахиулахын шинэчлэл” 2014 он.

22. Хууль дээдлэх ёс, Цуврал 63, 143 дахь тал, Л.Галбаатар “Гэрч, хохирогчийг хамгаалах нь”, 2017 он.

23. “Хүний эрх” цуврал нийтлэл, 33 дахь тал, Гэрч, хохирогчийг хамгаалах нь, 2012 он.

24. “Хүний эрх” цуврал нийтлэл, 46 дахь тал, Хохирогч хамгаалал, 2013 он.

25. “Хүний эрх” цуврал нийтлэл, 92 дахь тал, Эдийн бус хохирол нөхөн төлүүлэх эрх, 2013 он.

26. “Хүний эрх” цуврал нийтлэл, 46 дахь тал.

27. Гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх шатанд прокурор, цагдаа, гааль, тагнуулын байгууллагын уялдаа, түүний онцлог, 2013 он.

28. “Хүний эрх” сэтгүүл №2, 51 дахь тал, Б.Мөнхшүр “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн гэрч, хохирогчийн эрхийг хамгаалах зарим асуудал”, 2017 он.

29. Хүүхдийн эсрэг хүчирхийлэлд хариу үйлдэл үзүүлэх, насанд хүрээгүй гэрч, хохирогчтой харилцан НҮБ-ын стандарт, 78 дахь тал, “Гэмт хэргийн гэрч, хохирогч хүүхэдтэй холбоотой асуудлаарх шүүн таслах ажиллагаа загвар хууль, холбогдох тайлбар”, 2015 он.

30. Шинжлэх ухааны академийн мэдээ, №1 (221) “Гэмт хэргийн статистик зүйн онол, практикийн тулгамдсан асуудал”, 2017 он.

31. Шүүхийн ерөнхий зөвлөлийн судалгааны тайлан, 2017 он.

32. “Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном” Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, 2016 он.

ХҮСНЭГТЭН ДАХЬ ИШЛЭЛ

¹ ХЗДХ сайдын журмаас гадна ХТЭТ, ХЭҮТ-ийн нийгмийн туслалцаа үзүүлж буй байдалд ажиглалт хийснээр хамтад нь оруулж сайжруулахыг зорьсон болно.

² ХЗДХ сайдын 2017.2.14-ний өдрийн А/39 дүгээр тушаалаар батлагдсан “Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг түр хамгаалах журам”-ыг баримжаалав.

³ Бүртгэлийн гэрчилгээ олгохоос эхлээд улсын бүртгэлийн дэлгэрэнгүй лавлагаа авах хүртэлх үйлчилгээ багтах юм.

⁴ Нэг байршлаас нөгөө байршил руу ирэх, очих хугацаа, замын хөдөлгөөний нягтаршил зэргийг харгалзан дээд хугацаагаар тооцов.

⁵ Энэ нь анхан шатны зөвлөгөө өгөх хугацаа бөгөөд сэтгэл заслын эмчилгээ 2 жил хүртэл хугацаагаар үргэлжилдэг байна.

⁶ Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс.

⁷ Хог хаягдал зайлуулах, устгал, ариутгалд хамаарах бөгөөд хангамж, бараа материалын зардлын нэг хэсэг болдог байна.

⁸ Нэг ширхэг автомашинд ногдох зардал.

⁹ МУЗГ-ын 2005 оны 233 дугаар тогтоол “Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох журам, Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацаа, жилд байгуулах элэгдлийн хэмжээ”.

¹⁰ Мөн тэнд – Хоёрдугаар хавсралт, Үнийг дунджаар 800,000₮ гэж тооцоход 20% нь элэгдэл, хорогдол буюу 160,000₮ болно.

¹¹ Мөн тэнд – Хоёрдугаар хавсралт, Эд хогшил болох ширээ, сандал, шүүгээ, утасны аппаратын үнийг дунджаар 1,000,000₮ гэж тооцоход 10% нь элэгдэл хорогдол буюу 100,000₮ болно.

¹² ЗГ-ын 2002 оны 120 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчийн албан ажлын унаа, өрөөний талбайн хэмжээ, тавилга, хэрэгслийн нийтлэг жишиг”-т заасны дагуу нэг дэс түшмэлд ногдох ажлын өрөөний талбай 8м² талбай байна. Үүнээс 2,300,000,000₮ 4483м² = 513,049.29₮ нь 1м² талбайн өртөг бөгөөд 8м² талбайн өртөг нь 4,104,394.37₮ болно. Нэг албан хаагчид оногдох талбайн өртөг 4,104,394.37₮ гэж тооцоход 1,6% нь элэгдэл хорогдол буюу 65,670₮ болно.

¹³ Мөн тэнд. Түр хамгаалах байрны 1 хоногийн зардалд “Цалин, шимтгэл” гэдгийг нэгтгэн “цэвэрлэгээ, үйлчилгээний хөлс” гэж өөрчилсөн ба нийт үнийн дүнд өөрчлөлт ороогүй болно. /ажилтны цалин хөлсийг хүний нөөцийн зардалд тооцсон тул энд давхардуулан тооцох шаардлагагүй гэж үзлээ./

¹⁴ “Хохирогчийг хамгаалах байрны үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” MNS 6040:2009 Монгол Улсын стандартад зааснаар “Түр хамгаалах байр” гэж хохирогчийг хүлээн авснаас эхлэн 1 долоо хоногоос 3 сар хүртэлх хугацаанд тусламж, үйлчилгээ үзүүлэх газрыг хэлэх бөгөөд нийт зардлыг тооцохдоо дээд хугацаа болох 3 сар буюу 90 хоногийн хугацаагаар тооцов. Ингэхдээ Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2018 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн А/80 дугаар тушаалын хавсралтаар баталсан нэг хоногийн зардлыг 90 хоногоор үржүүлэн нийт дүнг гаргасан.

¹⁵ А/80 дугаар тушаалын хавсралтад бичиг баримттай холбоотой үйлчилгээний зардлыг тусгаснаас нийт дүнг авав.

¹⁶ Мөн тэнд. Нэг үйлчлүүлэгчид шаардлагатай уламжлалт болон орчин үеийн аргаар сэргээн засах үйлчилгээний дүнг нэгтгэн гаргасан.

---o0o---

ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn